

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Төрийн удирдлагын чиглэлээр:

2022 оны 4 сарын 3-аас 15-ны өдрүүдэд Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, Засаг даргын зөвлөхөөр ахлуулсан 4 ажлын хэсэг 4-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөдөөгийн 4 багт ажиллаж 510 өрхөөр орж орон нутгийн цаг үеийн мэдээлэл, цаашид хийхээр төлөвлөж буй ажил, арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн санал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын хамрагдалт, малын тоо толгойн татвар төвлөрүүлэх, гал түймэр гаргахгүй байх талаар гарын үсгийн баталгаа, мал төллөлтийн мэдээ, эмчийн үзлэг зэргийг зохион байгуулж явсан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Гал түймрээс урьдчилан сэргийлэх гарын үсгийн баталгааг насанд хүрсэн 600 гаруй иргэнээс авсан.

5 дугаар багийн Таванхонхорын шүүг Кензороуд ХХК-тай хамтран нөхөн сэргээлт хийлээ. Мөн тус багийн төвд төвлөрсөн их хэмжээний хогийн цэгийг булшилж цэвэрлэсэн. Эхний удаа Муруйн говьд зөвшөөрөлгүй хаясан хогийг цэвэрлэлээ.

4-р сард нийт 3 удаа төл хорогдлын мэдээг аймгийн ХХААГазарт хүргүүлсэн. 4-р сарын 22 өдрийн байдлаар сумын хэмжээнд төл бойжилт 52 хувьтай байна.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

Нийт үзлэг – 769

Урьдчилан сэргийлэх үзлэг – 96

Амбулаторийн үзлэг – 274

Идэвхитэй хяналт – 398

Гэрийн дуудлага – 61

Гэрийн эргэлт - 10

Яаралтай түргэн тусламжийн дуудлага – 96

Алсын дуудлага - 35

Нийт хэвтэн эмчлүүлэгч – 31

Ор хоног – 262

Нийт нас баралт – 2 (хавдар-2)

Халдварт бус өвчлөл эрт илрүүлэг үзлэг –

Артерийн гепиртензий – 140

Чихрийн шижин – 140

Хөхний өмөн – 37

Умайн хүзүүний өмөн – 100

Жирэмсний эрт хяналт - 17/13/76,4%

Төрсөн эх – 1

Сургалт сурталчилгаа

Цахим хуудас – 44 төрлийн мэдээлэл байршуулж 6999 хүний хандалт авсан байна.

Танхимын – 1 удаагийн 25 хүнд сургалт зохион байгуулсан.

Эмч нарын баярыг угтан эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд “Хамтдаа суралцаж-Хамтдаа ур чадвараа нэмэгдүүлье” ур чадварын тэмцээнийг зохион байгуулсан.

Эмч нарын баярыг угтан “Цай юу-Кофе юу” өглөөний зочинтой ярилцлагыг зохион байгуулж урилгаар Засаг дарга Б.Батсүх, Засаг даргын зөвлөх Ц.Ган-Өлзий, Засаг даргын орлогч Р.Биндэръяа нар оролцоо.

ЭМЯам, ЭМГазар хамтран зохион байгуулсан “Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ” сургалтанд ЭМТөвийн дарга, холбогдох мэргэжилтнүүд нийт 3 хүн 5 өдрийн сургалтанд хамрагдлаа.

“Монголын улаан загалмай нийгэмлэг, глобал сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт, эмчилгээ, хяналт болон нийгмийн дэмжлэг” төслийн хүрээнд хяналтанд эмчлэгдэж байгаа нэг иргэнийг 3 сарын хүнсний тусламжийн багцад хамрууллаа.

Илүүдэл жингүй эртэч монгол аяны хүрээнд "Бие бялдарын түвшин тогтоох сорил"-ыг СӨБ-ийн ажилчдын дунд зохион байгуулж нийт 25 багш ажилчид хамрагдлаа.

Аймгийн Боловсролын газрын зөвлөн туслах баг цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж СӨБ-ийн мэргэжилтэн бүлгийн багш нарын хөгжүүлэх үйл ажиллагаанд сууж заавар зөвлөгөө өгсөн.

6-н Бүлгийн багш, дуу хөгжим, ээлжийн бүлгийн нарын дунд Сайн хичээл” ур чадварын уралдаан зохион явуулж шалгарсан багш нь аймгийн ур чадварын уралдаанд оролцсон.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Би залуу багш” сургалтанд бүлгийн багш, Д.Болормаа, С.Цэвэлмаа, дуу хөгжмийн багш Т.Уугантулга нар хамрагдсан.

ХАБЭА-ын сарын аяны хүрээнд 6-н бүлгийн хүүхдийн өндөр жингийн үзлэг хийсэн

ХАБЭА-н сарын аяны хүрээнд "Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье" өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.

Байгууллагын багш, ажилчдад Монгол бичгийн анхан шатны сургалтыг сургуулийн багш Мягмарсүрэнг урьж заалгаж байна.

Соёл урлагийн чиглэлээр:

Зүүн бүсийн жишиг соёлын төвд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын соёлын төвийн хамт олон ажиллаж, туршлага судалласан. Хамрагдсан 9 хүн.

Сүхбаатар аймгийн Соёл Урлагийн Газраас зохион байгуулсан "Соёл урлагийн байгууллагын албан хаагчдын зөвлөгөөн" 2022.03.30-ны өдөр Баруун-Урт хотод зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд театр, номын сан, 12 сумын соёлын төвийн бүх албан хаагчид оролцож, соёл урлагийн удирдлага, номын сан, соёлын өв, бүжгийн урлаг, техникийн урлагийн

талаар салбар хэлэлцүүлэгүүд амжилттай зохион байгуулагдаж, туршлага судлалаа. Хамрагдсан 6 хүн.

Монгол улсаас Герман улсад ажиллаж байгаа Соёлын элч, Кума хөтөлбөрийн удирдагч Оюунтуяагаар ахлуулсан баг, Соёл, урлагийн газрын хамт олон Зүүн бүсийн жишиг соёлын төвд зочлон, хөтөлбөр үйл ажиллагаатай танилцан, хамтран ажиллах талаар санал солилцлоо. Хамрагдсан 7 хүн.

Монгол улсын соёлын тэргүүний ажилтан Баянмөнхийн Гүрбадамын “Дурлал шиг бүсгүй” аялан тоглолтыг танхимаар зохион байгуулж, 71 хүнийг хамруулсан.

“Илүүдэл жингүй эртэч монгол” аяны хүрээнд Сүхбаатар аймгийн биеийн тамир спортын газар, нийтийн бүжгийн “Gaaya dance” хамтран төрийн албан хаагч, иргэдийн дунд цэнгээнт бүжгийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 30 хүн хамрагдсан.

Монгол улсын Соёлын яамны соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг “Зүүн бүсийн жишиг соёлын төв”-ийн үйл ажиллагаатай танилцан, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Хамрагдсан 11 хүн.

Дэлхийн номын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд:

ЕБС-ын дотуур байрын сурагчдад “ Ном уншихын ач холбогдол, давуу тал” сэдвээр мэдээлэл өгч, танин мэдэхүйн “ Үсэглэлийн хаан” тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 45 хүүхэд оролцож, шагналт 2 байрыг шалгаруулсан. Энэ арга хэмжээгээр “Дэлхийн сонгодог зохиолууд болон шилдэг үлгэрээр” төрөлжсөн номын үзэсгэлэн гаргав.

“Талын түрлэг” номын талаар цахим танилцуулга хүргэсэн. Тэрбээр Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумаас төрсөн бахархалт хүмүүсийн түүхэн товчоо булангаар жанжин Д.Сүхбаатар, ардын баатар Г.Бүргэд, Монгол улсын гавьяат барилгачин Р.Буд, Монгол улсын гавьяат багш Х.Далхжав, Хөдөлмөрийн баатар Н.Осгон, МУ-ын Соёлын навьяат зүтгэлтэн Ц.Дашдондов нийт 8 хүний мэдээлэлийг цахимд байршуулаад байна.

Андерсоны үлгэр болон дэлхийн сонгодог шилдэг үлгэрийн номоор танилцуулга мэдээлэл өгч “Чанга уншлага” зохион явуулав. “Үнэт өв-үгэн эрдэнэ” номноос монгол ардын зүйр цэцэн үг цээжлэн , видео бичлэг хийж цахимд байршуулав. Эдгээр арга хэмжээнд 35 сурагч хамрагдав.

Аймгийн номын сангаас “Номын санчдыг чадавхжуулах сургалтанд 2 удаа хамрагдсан. Одоогоор 250 ширхэг номыг цахим праграммд бүртгэсэн. “Сүхбаатар сумын соёлын төв” , “ Соёлын төвийн номын сан” фэйсбүүк групп хуудсаар, шинэ номын танилцуулга-10, сургамжит өгүүллэг-6, мэдлэгт дусал нэмэр булангаар -12 мэдээлэл, тууж, роман-2 ыг цувралаар нийтлэж уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажилласан.

Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал хийдийн Тэргүүн Н.Цамбанүрдэв “ Эрдэнэ хийдийн түүх”, “Сүхбаатар аймгийн зарим сүм хийд, лам нарын баримтууд” - 4ш, Соёлын мэргэжилтэн Б.Золхүү “Уламжлал”, “Үнэт өв- үгэн эрдэнэ”-4 ш номыг хандиваар, худалдаагаар-110,000 төгрөгний үнэ бүхий “Талын түрлэг”, “Сономбалжирын Буяннэмэх, “Саруул талын найрагчид” нийт 12 ширхэг номоор баяжилт хийгдсэн.

4-р сард нийт үйлчилгээ-9 ном олгох үйлчилгээ-145, зөөврөөр – 1 удаа 35 номоор 5, байнгын уншигч-5, ирэгсэд-88 , цахим уншигчид-128 ,цахимд хөврүүлсэн ном-250

Сүхбаатар сумын Орон нутгийн хөгжлийн сангаас "Орон нутаг судлах музей, Соёлын төвд камер болон дохиололжуулалт" суурилуулах 11.904.000 төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ. Камер болон дохиололжуулалтын ажлыг Сүхбаатар аймгийн "Сүх өнө билэг" ХХК хийж гүйцэтгэн 2022.04.19-ний өдөр ажлын комисс хүлээн авлаа.

Орон нутаг судлах музейг Кума хөтөлбөрийн 7 хүн, Соёлын яамны газрын даргаар ахлуулсан 11 хүн, Түвшинширээ сумын соёлын төвийн 9 хүн, ЕБС-д сургалтаар ирсэн 7 хүн, аймгийн ИТХ-ийн төлөөлөгчөөр ахлуулсан 12 хүн, ЕБС-ийн 21 сурагч дөрөвдүгээр сарын байдлаар нийтдээ 67 хүнд музейн үйлчилгээг хүргэсэн.

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Сүхболд